



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/1039

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчийн бүртгэлээс  
барилга байгууламж хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 95 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн ерөнхий боловсролын 30 дугаар сургуулийн балансад бүртгэлтэй нийт 275,691,745.00 (хоёр зуун далан таван сая зургаан зуун ерэн нэгэн мянга долоон зуун дөчин тав) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 223,909,281.44 (хоёр зуун хорин гурван сая есөн зуун есөн мянга хоёр зуун наян нэгэн төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад дурдсан барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т зөвшөөрсүгэй.

2.Акталж, данс бүртгэлээс хасагдаж байгаа барилгыг буулгах, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдах боломжтой түүхий эд материалыг үнэлэн худалдаж, худалдсанаас орох орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 30 дугаар сургууль (П.Өлзийтөгс)-д даалгасугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (П.Хадбаатар)-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР



Нийслэлийн Засаг даргын 2024 оны  
.....08..... дугаар сарын .....29..... ны  
өдрийн Р/1039 дугаар захирамжийн  
хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл (2024.06.30)	Үлдэгдэл өртөг	Акталж данснаас хасах үндэслэл
1	Нийслэлийн ерөнхий боловсролын 30 дугаар сургуулийн хичээлийн А байр	1966	м2	3693	250,386,165.00	212,132,723.43	38,253,441.57	Монгол Улсын Мэргэжлийн Хяналтын Улсын байцаагчийн 2013 оны 02-07-89/694 дүгээр дүгнэлтээр буулгаж, шинэ барилга баригдах болсон
2	Биеийн тамирын талбай	2018	м2	461	25,305,580.00	11,776,558.01	13,529,021.99	
	Нийт дүн				275,691,745.00	223,909,281.44	51,782,463.56	